

# Нийгмийн тухай мэдлэг

**БАГШ:Д.ОЮУН**

# Бүлэг I. Нийгмийн тухай

- **Бүлгийн зорилго:**
- Нийгмийн хандлага болон төлөөлөгчид, нийгмийн түүхэн хэв маягууд, нийгмийн шинж, нийгмийн бүтэц, Моргань онол, Формацийн онол, Марксист онолын талаарх мэдлэгийг бататгах.

# Сэдэв: Нийгэм гэж юу вэ?

- **Сэдвийн зорилго:**
- Нийгмийн хандлагуудын төлөөлөгчид болох М.Вебер, Т.Парсонс, К.Маркс тэдний нийгмийг тодорхойлсон тодорхойлолт, үзэл хандлагууд, нийгмийн томъёолол, түүхэн хэв маягийн талаарх мэдлэгийг бататгах.

# Түлхүүр үгс:

- Нийгэм
- Тогтолцооны хандлага
- Шалтгаант чанарын хандлага
- Мөргөлдөөний онол
- Индивидуалист хандлага
- Институтын хандлага
- Соёл иргэншлийн онол
- Формацын онол
- Т.Маргоны онол



# “Нийгэм” гэх ойлголтыг тодорхойлох хандлага:

М.Вебер \Тогтолцооны хандлага\ - Нийгэм бол хүмүүсийн харилцан үйлдэл юм.

- Нийгэм гэдэг нь бусад хүмүүс болон үйл явдалд хандсан нийгмийн бүтээгдэхүүн болдог хүмүүсийн харилцан үйлчлэл юм.

Т.Парсонс \Шалтгаант чанарын хандлага\ - Нийгэм бол хэл, үнэлэмж, хэм хэмжээ зэргийг эхлэл болгодог тогтолцоо мөн.

- Холбогч эхлэлийн цэг нь хэм хэмжээ ба үнэт зүйлс байдаг хүмүүсийн хоорондын харилцааны тогтолцоо.

Ж.Хоманс, Ж.Линд, Ж.Мид \Индивидуалист хандлага\ - Аливаа нийгмийн үзэгдэл, тэр дундаа нийгмийн үндэс язгуурт байдаг.

- Аливаа нийгмийн үзэгдэл, тэр дундаа нийгмийн амьдралыг бодгалиудын цогц үйлдлийн дагуу тайлбарлаж болно. Нийгэм нь бие хүмүүс, тэдгээрийн хоорондын социал харилцааны цогц юм.

К.Маркс \Мөргөлдөөний онол\ - Ангиудын хоорондын зөрчил, тэмцэл нийгмийн үндэс язгуурт байдаг.

- Хөрөнгөтөн нийгмийн үндсэн ангиуд нь хөрөнгөтөн ба хөлсний ажилчин хоёр юм. Энэхүү 2 анги нийтлэг үнэт зүйлсгүй, эсрэг тэсрэг 2 анги тул байнга зөрчилдөж байдаг.

Нийгмийг тодорхойлох \Институтын хандлага\ - Нийгмийн институт(байгууллага)-н хүрээн дэх социал амьдралыг байгуулж, хэрэгжүүлж буй хүмүүсийн цогцыг **НИЙГЭМ** ГЭНЭ.

Институт нь нийгэм болон хүмүүсийн хэрэгцээ, тэдгээрийн хоорондын харилцааны тогтвортой болон байнгын шинж байдлыг бататган хангана.

# Нийгэм



- Нийгмийн харилцан үйлчлэл- Хүмүүс бие биедээ нөлөөлж, үйлчилж байдаг явц юм.
- Нийгмийн харилцаа- Хувь хүн ба нийгмийн бүлгүүдийн хооронд тогтсон харьцангуй тогтвортой, бие даасан холбоо, хамаарал.

# НИЙГЭМ

Өргөн утгаар томъёолбол: Тодорхой улс орны, ард түмний түүхэн хөгжлийн шатан дахь нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын дотоод, гадаад бат тогтвортой хамтын үйл ажиллагаа, харилцаагаар холбогдсон, хэрэгцээ болоод сонирхлын ялгаа, зөрчилдөөн бүхий хүмүүсийн зохион байгууллалтын хамгийн том нэгдэл.

- Хүмүүсийн зохион байгууллалттай, чиг зорилготой харилцаа, үйл ажиллагааны систем, тэдгээрийн үр дүнд бий болсон үнэт зүйлсийн нэгдэл. Мөн өөрийгөө байнга нөхөн сэргээж байдаг бие даасан тогтолцооны нийлбэр.

Явцуу утгаар томъёолбол: Нийгэм гэдэг нь чухамдаа хамтын амьдрал, харилцаа бүхий бие биедээ эерэг сөргөөр харилцан үйлдэл, үйлчлэл үзүүлэгч хүмүүсийн бүлгүүдийн цогц юм.

- Байнгын нутаг дэвсгэртэй, улс төр, эдийн засгийн бүрэн тусгаар тогтнолтой, бие даасан соёлтой, нийгмийг бүрдүүлэгч олон түмэн нь сэтгэл зүйн хувьд нэгдмэл шинжтэй байх хүмүүсийн том нийтлэг.

# Нийгэм

## Энгийн нийгэм

- Овог төрлийн холбоо
- Нийгмийн овог аймгийн зохион байгуулалт
- Нийгэм эд хөрөнгийн ялгаа гараагүй
- Анги давхраа, төр үүсээгүй
- \50000- 40000 жилийн өмнө үүссэн \

## Нийлмэл нийгэм

- Хүмүүс хоорондын олон янзын тогтвортой, өргөн холбоо харилцаа
- Нийгмийн ялгарал-давхраажилт\анги, давхраа, хөрөнгөтэй, хөрөнгөгүй, удирдагч, удирдуулагч\
- Нийгмийн олон түвшинд удирдах төр, засаг болон эрх мэдлийн ялгаа бий болсон.
- \10000- 6000 жилийн өмнө үүссэн\

# Нийгмийн түүхэн хэв маягууд

## Соёл иргэншлийн онол

( О.Шпенглерийн ангилал )

✓ Соёл иргэншлийн 8 хэв маягийг тодорхойлж,  
Залуу-Өсөлт-Уналтын гэсэн 3 үе шатыг дамждаг гэж үзнэ.

( А. Тойнбийн ангилал )

✓ Соёл иргэншлийн 13 хэв маягийг тодорхойлж,  
Үүсэл-Хөгжил-Өсөлт-Бууралт- Уналт-Бутрал гэсэн 6 үе шатыг дамждаг гэж үзнэ.


# Формацийн онол

1. Хүй нэгдлийн НЭЗФ
2. Боолын эзэмшлийн НЭЗФ
3. Феодалын НЭЗФ
4. Капиталист НЭЗФ
5. Коммунист НЭЗФ

- Хүний нийгмийг үйлдвэрлэлийн арга, өмчийн онцлогийг нь харгалзан эдийн засгийн үүднээс ангилах ангилал


- НЭЗФ- нийгмийн эдийн засгийн формаци

# Т.Морганы онол



## Эх сурвалж:

1. “Нийгэм судлал” хичээлийн ерөнхий боловсролын сурах бичгүүд
2. Д.Буян “Нийгмийн тухай мэдлэг”. УБ., 2011
3. Орчуулсан Б.Батчулуун “Философи”. УБ., 2012
4. О.Пүрэв, С.Нямзагд, Р.Дарьхүү, Г.Сайнхишиг, Д.Буян, Т.Алтанцэцэг “Нийгмийн ухаан”. УБ., 2012
5. Б.Амгаланбаяр, Т.Сайхнаа “Хичээлүүдийн лавлах”. УБ., 2014



**Анхаарал хандуулсанд  
баярлалаа.**

